



## НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/58

Улаанбаатар хот

### Сургалт, сурталчилгааг зохион байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 13 дугаар зүйлийн 13.2, 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Онцгой байдлын байгууллага нэгдсэн тогтолцоонд шилжсэний 15 жилийн ойг тохиолдуулан нийслэлийн иргэдэд Онцгой байдлын албаны үйл ажиллагааг сурталчлан таниулах, гамшгийн аюулын талаарх болон гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг хүргэх, гамшгийн үед өөрийгөө болон бусдыг аврах, бусдад туслах арга ажиллагааны талаарх мэдлэг олгох сургалт, сурталчилгааны нэгдсэн арга хэмжээг 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 10:00-17:00 цагийн хооронд Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит талбайд зохион байгуулсугай.

2. Арга хэмжээний удирдамжийг нэгдүгээр, шаардлагатай зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт, сурталчилгааны нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 3.200.250 (гурван сая хоёр зуун мянга хоёр зуун тавин) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

4. Сургалт, сурталчилгааны нэгдсэн арга хэмжээг удирдамжийн дагуу чанар, үр дүнтэй зохион байгуулахыг Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэс (хурандаа Г.Нэргүй), Гал түймэртэй тэмцэх хэлтэс (хурандаа Д.Мөнхсайхан)-т тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга (дэд хурандаа Н.Нямхорлоо)-д даалгасугай.

ДАРГА,  
ХУРАНДАА  Ж.ЧҮЛТЭМСҮРЭН



Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын  
2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн  
188 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

1117155609  
УХА0038 9077073

ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ СУРТАЛЧЛАХ  
СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Онцгой байдлын албаны үйл ажиллагааг иргэдэд сурталчлан таниулах, алба хаагчийн ажил мэргэжлийн онцлог, гал түймэр унтраах, аврах ажиллагааны автомашин, багаж зэвсэглэмж, техник хэрэгслийг танилцуулах, гамшгийн аюулын талаарх болон гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг хүргэх, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд олон нийтийн хандлагыг өөрчлөх, оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

Хоёр. Зохион байгуулах хугацаа

Сургалт, сурталчилгааны нэгдсэн арга хэмжээг 2019 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн 10:00-17:00 цагт Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит талбайд зохион байгуулна.

Гурав. Зохион байгуулах сургалт, сурталчилгааны ажлын чиглэл

1. Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийг таниулан сурталчлах, гамшгийн аюул, түүнээс урьдчилан сэргийлэх, гамшиг тохиолдсон үед өөрийгөө болон бусдыг хамгаалах аргад сургах сургалт зохион байгуулах;

2. Болзошгүй аюулт үзэгдэл, осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэж, гарын авлага, сэрэмжлүүлэг материал тараах;

3. Нийслэлийн Онцгой байдлын газрын танилцуулга баримтат кино, гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэг шторкийг гудамж талбайд байрлах ЛЕД дэлгэцүүдээр нэвтрүүлж олон нийтэд хүргэн сурталчилах;

4. Хэлтэс анги, байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчлан таниулах, онцгой байдлын албаны алба хаагчийн ажил мэргэжлийн онцлог, автомашин, багаж зэвсэглэмж, техник хэрэгслийг танилцуулах, гал унтраах болон аврах ажиллагааны үзүүлэх сургууль зохион байгуулах.

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын  
2019 оны 06 дугаар сарын 18 -ны өдрийн  
А/58 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ НЭГДСЭН СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНД  
ШААРДЛАГАТАЙ ЗАРДЛЫН ТООЦОО**

д/д	Материалын нэр	Дүн
1.	Бусад зардал	2,843,250.0
2.	Шатахуун	357,000.0
<b>НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>3,200,250.0</b>

Нэг. Бусад зардлын тооцоо					
№	Материалын нэр	хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо хэмжээ	Нийт үнэ
1	Хөгжим апартурын түрээс	ком	1,300,000.0	1.0	1,300,000
2	Туг мандуулах түрээс	ш	105,000.0	9.0	945,000
3	Хөөсөнцөр хаяг 3м*30см	ш	19,800.0	10.0	198,000
4	Хулдаасан хэвлэл 6.5м*5м	м	7,700.0	32.5	250,250
5	Гэрэлтүүлэг түрээс зардал	ш	150,000.0	1.0	150,000
<b>Бусад зардлын дүн</b>					<b>2,843,250</b>

ШААРДЛАГАТАЙ ШАТАХУУНЫ ТООЦОО										
№	Байгууллага	Автомашин		100 км		Рейс тоо	Шатахууны тооцоо			
		марк	дугаар	норм	зай, км		төрөл	хэмжээ, л	нэгж, төг	нийт, төг
1	НОБГ	Старекс	УНЯ 55-49	18	10	5	АИ - 92	9	1,940	17,460
2		Старекс	УНО 01-05	18	10	5	АИ - 92	9	1,940	17,460
3		Газель	УБС 43-94	22	10	5	АИ - 92	11	1,940	21,340
4		Квадратцикль	47-01 УБ	9	10	5	АИ - 92	4.5	1,940	8,730
5		Квадратцикль	47-02 УБ	9	10	5	АИ - 92	4.5	1,940	8,730
6		Сургалтын автобус	48-89 УБИ	45	10	5	ДТ	22.5	2,240	50,400
7		Вифер	57-66 УБС	22	10	5	ДТ	11	2,240	24,640
8		Volkswagen	85-47 УБЧ	20	10	5	ДТ	10	2,240	22,400
9		Автобус	87-42 УБЧ	22	10	5	ДТ	11	2,240	24,640
10		Прадо	01-88 УНП	18	10	5	АИ - 92	9	1,940	17,460
11		Киа Рио	08-41 УНУ	9	10	5	АИ - 92	4.5	1,940	8,730

12		Киа Рио	08-42 УНУ	9	10	5	АИ - 92	4.5	1,940	8,730
13		Киа Рио	08-43 УНУ	9	10	5	АИ - 92	4.5	1,940	8,730
14		Киа Рио	08-46 УНУ	9	10	5	АИ - 92	4.5	1,940	8,730
15		Старекс	УНТ 87- 62	18	10	5	АИ - 92	9	1,940	17,460
16		Уаз ФЕрМЕР	95-53 УБХ	18	10	10	АИ - 92	18	1,940	34,920
		зил-130	58-79 УБЛ	38	15	3	АИ - 92	17.1	1,940	33,160
17	ЧДОБХ	101		12	10	10	АИ - 92	12	1,940	23,280
ДҮН					185. 0	98.0	-	175.6		357,000

--oOo--